



НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД ОЛГОХ ТЭТГЭМЖ

ТЭТГЭМЖ ОЛГОХ НӨХЦӨЛ

- Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг 36 сараас доошгүй хугацаанд төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барсан бол;
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэн нас барсан бол.

ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ

- Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж 2 000 000 /хоёр сая/ төгрөг;
- Нас барсан даатгуулагч амьгүй донор болж эс, эд, эрхтэнээ бусдад шилжүүлсэн бол 3 500 000 /гурван сая таван зуун мянган/ төгрөг байна.



БҮРДҮҮЛЭХ БАРИМТ

- Нас барсны гэрчилгээ;
- Өргөдөл;

ГАР УТАСНААСАА САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ АВАХ БОЛОМЖТОЙ

- ✓ Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах
- ✓ Сайн дурын даатгалын шимтгэлээ төлөх
- ✓ Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн мэдээллээ жил, сараар харах, хянах, хэвлэх
- ✓ Нийгмийн даатгалын байгууллагаас авсан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн мэдээллээ харах
- ✓ Санал хүсэлтээ цахимаар илгээж шийдвэрлүүлэх

“МИНИЙ ТЭТГЭВРИЙН МӨНГӨН
ХУРИМТЛАЛ”-ЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛЭЭ
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
АПЛИКЕЙШН-ЭЭС АВНА УУ!

NDAATGAL 2.0
Хувьцаа

ТАНЫ ГАР УТсанд



ГАР
УТАСНЫХАА



НД-ЫН АПП-АА
ШИНЭЧЛЭЭРЭЙ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**



ТЭТГЭМЖИЙН
ДААТГАЛ

ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛД ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГООС

Даатгалуулагчийн төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ
Ажил олгогч	1.0
Албан журмын даатгуулагч	0.8
Сайн дурын даатгуулагч	1.0



ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САНГААС

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж;

Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж;

Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн төлбөр.



ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ

Хөдөлмөрийн чадвараа түр алдахын өмнөх дараалсан 3 ба түүнээс дээш сар тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч доор дурдсан тэтгэмж авах эрхтэй:

- Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан;
- Хүүхдээ 196 хоног хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу Эрүүл мэндийн тухай хуулийн 32.1-д заасан үндэслэлээр үр хөндүүлсэн.



ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлсөн сүүлийн 3 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас дараах хувь хэмжээгээр тооцно:

Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа /сараар/	Тэтгэмж бодох хэмжээ /хувиар/
3-59	50
60-119	55
120-179	60
180 ба түүнээс дээш	75



ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний амралт авахын өмнө 12 сараас доошгүй хугацаанд үүнээс сүүлийн 6 сард тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.



ИХЭР ХҮҮХЭД ТӨРҮҮЛСЭН БОЛ ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ НЭМЭГДЭНЭ

Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 4 сар (ихэр хүүхэд төрүүлсэн бол 4 сар 20 хоног)-ын хугацаанд сүүлийн 12 сарын цалин хөлс, орлогын дунджаас **100 хувиар** тооцож олгоно.

Жирэмсний болон амаржсаны тэтгэмж бодох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцож жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг нэмэгдүүлэн олгоно.



БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас /цахимаар эсхүл цаасаар/



БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудас /цахимаар эсхүл цаасаар/